



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 100


Улаанбаатар хот

Хорооны 2009 оны 38 дугаар тогтоол  
болон хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 38 дугаар тогтоолын 3 дахь заалтын “Хуульч, үнэлгээчин, аудитын компанийг хүлээн зөвшөөрөх...” гэснийг “Хуулийн компани, аудит, үнэлгээний байгууллагыг бүртгэх тухай журмын болон...” гэж, энэхүү тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай” журмын 2.2.1 дэх заалтын “Хороо хүлээн зөвшөөрсөн аудитын компанитай...” гэснийг “Хороонд бүртгэгдсэн аудитын байгууллагатай...” гэж, мөн журмын 2.2.2 дахь заалтын “Хороо хүлээн зөвшөөрсөн үнэлгээчинтэй гэрээ байгуулан компанийн үл хөдлөх хөрөнгийн...” гэснийг “Хороонд бүртгэгдсэн үнэлгээний байгууллагатай гэрээ байгуулан компанийн хөрөнгийн болон бизнесийн...” гэж, мөн журмын 2.2.3 дахь заалтын “Хороо хүлээн зөвшөөрсөн хуульчтай...” гэснийг “Хороонд бүртгэгдсэн хуулийн компанитай...” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Журамд нэмэлт, өөрчлөлтийг оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж, нийтэд мэдээлж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.



ДАРГА

Д.БАЯРСАЙХАН